



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо:	2026 оны 1 дүгээр сарын 23
Зээлийн дугаар ба нэр:	L3679/3786-MON: Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл
Гэрээний дугаар ба нэр:	UA2: Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын дагуух Онгийн голын төмөрбетон гүүрийн их засварын ажил
Тендер хүлээн авах эцсийн огноо ба цаг:	2026 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 15:00 цаг /Улаанбаатарын цагаар/

1. Монгол Улс Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-наас **Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын төслийг** хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурьдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана. Тендер шалгаруулалт нь АХБ-ны эрх бүхий орны тендерт оролцогчдод нээлттэй байна.
2. Зам, тээврийн яам нь (цаашид “захиалагч” гэх) эрх бүхий тендерт оролцогчдоос **“UA2: Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын дагуух Онгийн голын төмөрбетон гүүрийн их засварын ажил”** (цаашид “ажил гэх”) гүйцэтгэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.
3. Энэхүү тендер шалгаруулалтыг АХБ-ны дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтын аргаар явуулна.
4. Зөвхөн дор дурдсан чадварын үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий тендерт оролцогч энэхүү тендер шалгаруулалтад оролцоно. Үүнд:
 - Дараах тусгай зөвшөөрлүүдтэй байх. Үүнд: Зам, тээврийн яамны: (i) Авто зам барих; (ii) Замын байгууламж барих;
 - Сүүлийн 5 жилд (2020, 2021, 2022, 2023, 2024) амжилттай эсхүл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд үндсэн гүйцэтгэгч, түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн хувиар оролцсон байх, ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь **1.5 тэрбум төгрөгөөс доошгүй** байна. Тендерт оролцогчийн гүйцэтгэсэн ажлын ижил төстэй байдлыг дараах шинжид үндэслэн тодорхойлно. Үүнд: 20 метрээс дээш урттай төмөр бетон гүүрийн засвар, шинэчлэлийн ажил;
 - Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлагын доод хэмжээ: Сүүлийн 5 жилийн хугацаанд нэг гэрээний хүрээнд хамгийн багадаа 20 у/м буюу түүнээс дээш урттай төмөр бетон гүүрийн засвар, шинэчлэлийн ажил гүйцэтгэсэн байх;
 - Сүүлийн 5 жилд (2020, 2021, 2022, 2023, 2024) хэрэгжиж дууссан эсхүл хэрэгжиж байгаа гэрээт ажлын хүрээнд хүлээн авсан баталгаат төлбөрийн нийт дүнгээр тооцсон барилгын ажлын борлуулалтын доод хэмжээ нь дээрх жилүүдээс дурын **3 жилийн дунджаар 1.7 тэрбум төгрөгөөс доошгүй** байна;
 - Энэ гэрээнд шаардагдах санхүүгийн нөөц хөрөнгө нь **430.0 сая төгрөгөөс доошгүй** байх.
5. Сонирхсон тендерт оролцогч тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дараах хаягаар авч болно.

Захиалагч : Зам, тээврийн яам
Харилцах ажилтан : Авто замын бодлого зохицуулалтын газрын
мэргэжилтэн Д.Заансүх
Гудамж : Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Чингисийн
Өргөн чөлөө-11, Засгийн газрын 13-р байр
Давхар/өрөөний : 4 давхар, 407 тоот
дугаар
Хот : Улаанбаатар хот
Улс : Монгол улс
Утас : +976 88094104, +976 99192238
Цахим шуудангийн хаяг : zaansukh@mrt.gov.mn

6. Эрх бүхий тендерт оролцогч тендерийн баримт бичгийг худалдан авахыг хүсвэл:
- “UA2: Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замын дагуух Онгийн голын төмөрбетон гүүрийн их засварын ажил”-ын тендерийн баримт бичиг авах хүсэлтийг дээр хаягийн дагуу бичгээр ирүүлнэ.
 - Төсөл хэрэгжүүлэх нэгжийн дараах дансанд **250,000 төгрөгийг** буцаан үл олгогдох хураамжийг төлсөнөөр Тендерийн баримт бичгийг худалдан авч болно.
 - Дансны нэр: Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл
 - Банкны нэр: Төрийн сан
 - Дансны дугаар (Төг): 330090100900011888
7. Тендерийг дээр дурдсан хаягаар
- Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө: **2026 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 15:00 цаг**
 - Тендерийн баримт бичигт шаардсан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Тендерийг тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссан даруйд тендерийн нээлтэд оролцохыг хүссэн эрх бүхий оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.